



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 488

Улаанбаатар хот

Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.8, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 10 дугаар зүйлийн 10.5, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ”-ний 6.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 4.8, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн ЗГ-2/436 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Юу Би сити хаусинг девелопмент” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллаж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн явуулахыг “Юу Би сити хаусинг девелопмент” ХХК /Б.Батзориг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт, тавьж олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН